

89-91 ОНД ХОЖУУ ХАНЬ УЛСААС УМАРД ХҮННҮ УЛСЫГ ДОВТОЛСОН ТҮҮХИЙН АСУУДАЛД

Б.БАТСҮРЭН

Товч агуулга: *Өмнөд хүннү, ху, жун, ди, цян, ухуань* нарын нүүдэлчдийн цэргийн хүч ашиглаж Хожуу Хань улс 89-91 онд гурван ч удаа Умард Хүннүг довтолж шаньюйтай нь хэдэнтээ тулалдаж хөөж явуулахыг оролдсоноор тус улсыг мөхөөсөн гэж үзсээр ирсэн. Мөн энэ байдлааныг Хожуу Хань улс аюулгүй байдлынхаа төлөө явуулсан дайн гэж үздэг. Умард Хүннүг 91 онд мөхсөн эсвэл Хожуу Хань улс өөрийнхөө аюулгүй байдлын төлөө явуулсан дайн байсан гэж үзэгч эрдэмтдийн онол, үзэл баримтлал түүхэн бодит байдалтай нийцэж буй эсэхийг өгүүлэлдээ тодруулахыг зорилоо.

Түлхүүр үг: Умард Хүннү, Өмнөд Хүннү, Хожуу Хань, ханьгийн Доугийн гэр бүл

Хүннү гүрэн угсаа-газар зүйн хүчин зүйл, хамгийн гол нь шаньюй (**darɣwa* \ *daɣa*)-н алтан ургийн хүчирхэг салаа хоорондын зөрчлөөс болж хоёр хуваагдсан ч хүн ам нь бараг тэр чигээрээ монгол хэлтэн «жинхэнэ хүннү аймгуудаас» бүрэлдэх Умард Хүннү 49 оны өвлөөс 83 оны зун хүртэл 34 жилийн турш урьдын адил хүч чадалтай хэвээр байв. “Умардынхан хүчтэй хэвээр байсан нь [тэднийг¹] удаан хугацаанд Пуну захирч байсантай холбоотой” гэж Т.Барфилд үзжээ.²

¹ Энэ хэсэгт *умард хүннүчүүд* “... хятадын фронтирыг амжилттай уулгалж байсан” гэж Т.Барфилд бичсэн. Хятадыг л уулгалахгүй бол хүннүгийн төр оршиж үл чадна гэж тэрээр бат итгэдэг. Харин сурвалжийн мэдээг ягштал баримтлах аваас 49-83 онд *умард хүннүчүүд* Ханьгийн хилд 3 удаа л довтолжээ. Нэгд, Хүннү, Ханьгийн харилцааг зохицуулж байсан гэрээг сунгахгүй байсан учир *умард хүннүчүүд* анхааруулж гахай жилийн өвөл (62.11.21-63.2.16) Ханьгийн хилд нэг том түмт цэргээр халдсан байдаг. Хоёрт, уг явдлаас гурван жилийн дараа намар (65.8.21-11.16) цагт *өмнөд хүннү* нараас урвуулж хойш нүүлгэх даалгавартай Умард Хүннүгийн нэг бага түмт цэрэг хэрэг илэрч бүтэлгүйтсэн тул буцахдаа Шофан тойргийн хэдэн сууринг уулгалжээ. Гуравт, 73 оны II сард (2.26-3.27) Хань, Өмнөд Хүннүгийн их цэрэг Хүннүгийн нутагт довтолсны хариуд нь Юньчжун тойргийг довтолжээ. Энэ хугацаанд *өмнөд хүннүчүүд* 4 удаа (49, 50, 73, 76 он), Хань улс 1 удаа (73 он) Хүннүг дайлсан. Болж өнгөрсөн түүхэн үйл явдал ийм байсаар атал бас эртний хятадын бичгийн мэргэд өөрсдийн нутагт нь халдах тохиолдол болгоныг ягштал тэмдэглэж үлдээдэг уламжлалыг бодолцвол «хүннүчүүд маш олон удаа хятадын фронтирыг уулгалж байсан» гэж дүгнэх нь утгагүй ба уншигчдад худлаа мэдээлэл, мэдлэг тулгаж байгаа хэрэг болно.

² Barfiel T.J. *The Perilous Frontier. Nomadic Empires and China 221 BC to AD 1757*. Blackwell Publishers, 1992, p. 79

Дашрамд дурдахад, эртний хятадын түүхийн томоохон мэргэжилтний нэг *швед* эрдэмтэн Ханс Биленштейн 1967 оны бүтээлдээ Пуну (*bana) шаньюй (*daruγa)-г 83 онд нас барсан гэж бичсэн байдаг.³

Өрнийн хоёр эрдэмтний саналыг дагавал Умард Хүннүгийн эхэн үеийн төрийн тогтвортой байдал Пуну шаньюйтай шууд холбоотой болох нь.

Гэвч 83 оны эхэн хагаст дал, наяд настай⁴ байсан Пуну шаньюй нас барав.

Пуну-г нас барсаны дараа умард хүннүд улс төрийн хямрал болж, үймээн самууны хөлөөр ганц нэг аймаг нутаг усаа орхиж нүүсэн гэж Т.Барфилд бичжээ.⁵

Пуну-г залгамжилсан шаньюйн нэр гэж утга үсгийн сурвалжид байхгүй. Харин хятад судлаач *австрали* эрдэмтэн Рейф де Креспиньи 87 онд *сяньбичуудад* алагдсан Юлю шаньюйг Пуну шаньюйн залгамжлагч гэж үзсэн.⁶ Хожим өрнөсөн үйл явдлаас үзвэл Юлю (*ɣuliu, *ɣəw-ɣhjəw, эсвэл *buru⁷) шаньюй Пуну-г залгаж Умард Хүннүгийн төрийг барьсан гэж үзэх нь зөв бололтой.

Пуну шаньюйн үеийн умард хүннүгийн хүч чадал Юлю шаньюйн үед аажмаар алдагдаж эхэлсэн. Магадгүй тэд дотооддоо хэсэг зуур боловч үймж, бужигнасан байх. Алин ч бай умард хүннүгийн улс төр тогтворгүй болсоны нэг илрэл нь Т.Барфилдын хэлсэнчлэн бүлэг *хүннүчүүд* Хожуу Хань улсад дагаар орсон явдал болно.

Сурвалжийн мэдээгээр, Хожуу Ханьгийн Чжан хааны жяньчугийн 3-р оны зуны адаг сард (83.7.4-8.2) Саньмулоузы⁸-гаар дайран умард хүннүгийн Гилюсы (*kirusu) ноён 38 мянган хүн дагуулж, 2 түм адуу, 1 бум үхэр, хонь тууж Уюань-ий бэхлэлт хэрмийн гадна ирж дагаар оржээ.⁹

³ Bielenstein, H. "The Restoration of the Han dynasty", Vol. III. *The People – BMFEA*. No 39. Stockholm, 1967, p. 90.

⁴ М.Э. I зууны эхний Хүннүгийн шаньюй нар урт насалсан бололтой. Жишээ нь, Юй Худуэрши шаньюй Хүннүгийн төрийн эрхийг атгаж эхлэхдээ хэдийн тавин нас хүрсэн ба харин далан хэд бараг наяд дөхөж хальжээ. М.Э.Ө. 31 оноос хойш мөрдөж байсан уламжлалаар өөрийгөө шаньюй болох ёстой гэж бодож, тооцоолж явсан Жичжу (*nintuk) ван Би ч гэсэн М.Э. 46 онд тавин хэдээс жараад настай байсан бол Юй шаньюйг залгамжлаад тун удалгүй нас барсан Удадихоу (*ʔahdattaiɣuh, *ʔadatdego, *qalatdego) шаньюй ч гэсэн тавь-жартай нэгэн байжээ. Жичжу ван Би-д хаан ширээ өгөлгүй өөрөө шаньюй болсон Пуну ч гэсэн хижээл настай нэгэн байсан болов уу, чухам дөчөөд настай байсан байх.

⁵ Barfield T.J. *The Perilous Frontier. Nomadic Empires and China 221 BC to AD 1757*. Blackwell Publishers, 1992, p. 79

⁶ de Crespigny, R. *Northern Frontier. The Policies and Strategy of the Later Han Empire*. Canberra, ANU., 1984, p. 264 (хойшид, *Northern Frontier*).

⁷ Юлю 優留-гийн Хожуу Ханьгийн үеийн дуудлага ЛН. *ɣuliu (А.Шюсслер), ЕН. *ɣəhwljəhw*ɣulju (С.Коблин), ВХ. *ɣəw-ɣhjəw (С.А.Старостин) болно. Харин 164\5?-188 онд Лоян-д байсан *юэчжи* лам Локакшема (Чжи Лоуцзячэнь, 支婁迦讖)-гийн орчуулгаар бол *buru болох аж.

⁸ Тус нэрийг ВХ. *səmmhōkrwācǰé (С.А.Старостин), ЛН. *səmmuklozie (А.Шюсслер) гэж сэргээнэ.

⁹ *Хоу Ханьшу*, 3, 145; 89, 2950; Таскин В.С. *Материалы по истории сюнну (по китайским источникам)*. Выпуск 2. М., 1973, стр. 79 (хойшид, *Материалы по истории сюнну*, вып. 2).

Хүннүгийн дотоод нөхцөл байдал ямар байсныг тодорхой мэдэх боломжгүй бол харин гадаад харилцаа ямар нэг байдлаар үргэлжиж байсныг сурвалжийн мэдээ баримтаас харж болдог.

Шаньюй болсны дараа өмнөх хаадын тогтоосон гэрээ хэлэлцээг шинэчлэн баталдаг уламжлалаар Юлю шаньюй Увэй тойргийн хилийн боомт руу элч илгээж Хожуу Хань улстай урьдын ёсоор харилцаж, худалдаа наймаа хэвээр үргэлжлүүлэх бодолтой байгаагаа мэдэгдэв. Дараа нь 84 онд Имози (*ʔimaksie) нарын ноёдод худалдаж арилжих үлэмж тооны үхэр, адуу өгч Хожуу Ханьгийн хилийн боомт зүг илгээжээ. Хожуу Ханьгийн хилийн тойргийн хот суурингууд ч зах зээлээ нээж худалдаа арилжаа явуулжээ. Хоёр улсын харилцаа ийнхүү хэвийн болох нь *өмнөд хүннүчүүдэд* ямар ч ашиггүй тул тэдний өмнөд хүннүгийн тоглоомын шаньюй цэрэг илгээж *хүннү* нарыг довтолж мал сүргий нь дээрэмдэж тонов.¹⁰

Түүнээс гадна сурвалжид “энэ цагт умардын зэрлэгүүдийн хүч суларч доройтов. Хамсаатнууд нь салан одов. Урдаас нь *өмнөд хүннүчүүд* довтолж¹¹, араас нь *динлин* нар уулгалж, зүүнээс нь *сяньбичууд* дайлж, харин *баруун газрынхан* өрнөөс нь хавчин шахах болов”¹² гэсэн мэдээ үлдсэн байдаг. Үнэн бол Хүннүг ингэж тал талаас нь хяхан хавчиж, уулгалан довтолохыг бусадтай үгсэн хуйвалдаж, амжилттай зохион байгуулж чадах боломжтой этгээдийн нэг нь яах аргагүй Өмнөд Хүннү билээ.

Гэхдээ *хожуу ханьгийнхан* эртнээс их шан амлаж харь угсаатныг харь угсаатны хүчээр устгах бодлого барьж, турхирч байсныг мартаж болохгүй. Тэгээд ч тэд *ухуань*, *сяньби* нарт хахууль цутгаж, тэд нар нь Хүннүг зүүн талаас байнга уулгалан довтолдог байлаа. Бас *өмнөд хүннү* нарыг ч гэсэн алж олзолсон хүний тоогоор шагнаж урамшуулж байв.¹³

Хожуу Ханьгийн хаад энэ бодлогоо амьдралд бодитой хэрэгжүүлж амжилт олж байсан баримт сурвалжид үлджээ. Тухайлбал, Туньгүхэ (*ʔwəndāyā < *tödägä)-н хэлснээр 88 оны 4-р сард үхсэн Чжан хаан холыг харж, зөв тооцоолон төлөвлөж, аливаа үйл хэргээ төгс амжилттай дуусгадаг чадвараараа ялгарч байсан ба *ухуань*, *сяньби* нарыг ухуулан сэнхрүүлж умардын зэрлэгүүдийн эсрэг аян дайнд хөдөлгөн мордуулж, зэрлэгүүдийн улс гэрийг нь сүйтгэж, арваад мянгыг

¹⁰ *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 79-80

¹¹ Өөр мэдээгээр 85 оны дундуур! өмнөдийн 1000 эр авлах нэрээр хил давж Жое (*tokga) уулын хүннүг довтолж *вэньюйду* (*ʔwənjūodok < *onjūd) ванг алжээ (*Хоу Ханьшу*, 89, 2950).

¹² *Материалы по истории сюнну*, вып, стр. 80

¹³ Таскин В.С. *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. М., 1984, стр. 66, 67, 71; *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 81, 152; *Northern Frontier*, p. 262; Тогтох. *Эсгий туургатны түүх. Хүннүчүүд*. Доорд. Дэжу, Чойжи орчуулав. ӨМАХХ., 1993, т. 1013 (хойшид, *Эсгий туургатны түүх*).

алж, олзлон, хаан эзнийх нь толгойг огтолж авчруулж чадсан гавьяатай¹⁴ гэж үнэлэгдэж байна.

Умард Хүннүг эхний удаа хавсайдаж дайлсан нь барагцаалбал 85 оны хавар-намар болжээ. Үүний дараа Хүннүг биеэ дааж чадахгүй болсон, тэгээд нүүж улам холдсон гэж хятад түүхчид бичжээ. Чухам хүннүүчүүд урьдын хүч чадлаа алдаж, хавь ойрын харь овог, аймаг, хот-улсуудыг захирч чадахаа больжээ л гэсэн үг.

Хүннүг гурван талаас нь нэг зэрэг дайрахын өмнөхөн 85 оны нэгдүгээр сард (2.13-3.14) умард хүннүгийн ахлагч Гюйли (Чэли, *kaŋi), Жобин (*təkrep) нар бэхлэлт хэрмийн гадна 73 хүн дагуулж зугтаж ирсэн¹⁵ мэдээг дараахан нь болсон өмнөд хүннү, сяньби, динлиний довтолгоонтой холбож үзвэл тэд нар уулаас хүннүүчүүдийн дунд байсан туршуул эсвэл зугтаж ирээд мэдээ өгсөн урвагчид гэж харагдахаар байна.

85 оны өвөл (85.11.6-86.2.1) өмнөд хүннүүчүүд Хожуу Хань улсын хатгалгаар дахин хэдэн мянган хөнгөн хуягт морьт цэргээр Хүннүг довтолж хүннүгийн мянгаад хүнийг алж, хариад авах шан харамжийнхаа гэрч болгож мянгаад толгой огтолж буцсан байна.¹⁶

Харин, 86 оны 2-р сарын эхнээс 87 оны 4-р сарын хорьд хүртэл нэг жил хоёр сарын хугацаанд Хүннүд юу болж өнгөрснийг мэдээлсэн баримт хараахан олж үзсэнгүй.

Хүннүгийн шаньюйн ордоос гахай жилийн хавар гарч өмнөд хүннүд зугтаж ирсэн Сюйцюй (*q^haga)-н мэдээлснээр бол Юлю шаньюй гурван сард (4.21-5.20) өргөө гэрээ Аньси¹⁷ (*qalawu) хэмээх газраас нүүлгэж Аньхоу¹⁸ (*ʔānywā<

¹⁴ *Материалы по истории сюнну, вып. 2*, стр. 81, 152

¹⁵ *Хой Ханьшү*, 89, 2950; Parker E.H. *Turko-Scythian tribes-After Han dynasty – The China Review*. Vol. XXI, No 4, 1895, p. 263 (хойшид, Han dynasty); Эсгий туургатны түүх, т. 1012

¹⁶ *Han dynasty*, p. 264

¹⁷ Хүннүгийн орд өргөө байрлах газрыг “Гянькунь (Гэкунь)-аас зүүнээ 7 мянган ли-д шаньюйн ордон, өмнө зүг 5 мянган ли-д Гүши (Жүши\Чэши) байдаг” гэж Хань улсын бичигт тэмдэглэсэн бол «Вэй улсын товч түүх»-д “Гяньгунь (Kien-kouen) ... хүннүгийн шаньюйн Аньси (Ngansi) голын ордноос 7 мянган ли, өмнө зүгт Гушийн зургаан улсаас 5 мянган ли” (*Хань улсын бичиг*, 94, 3800; Chavannes É. *Les pays d'occident d'après le Wei lio – T'oung Pao*. Ser. 2. Vol. VI, Leide, 1905, p. 560) зайтай гэж тодруулжээ. Эл хоёр мэдээгээр бол хүннүгийн шаньюйн орд өргөө лав м.э.ө. тавиад оноос хойш Аньси (安習) гэдэг газар байжээ, зүг байршлыг нь ч тодорхой мэдээлж байна. Аньси гэсэн нэрийг – ЗХ. *ʔānlhəp; ОСМ. *ʔānləp; ОС. *qaanljub буюу *qā-ljub, *qā-ləp ~ *qā-lhəp гэж сэргээж болох ба Монголын нууц товчоонд «галуу» гэхийг «qalawu» гэж тэмдэглэдэг. Өөрөөр хэлбэл бид, хүннүгийн хааны ордон байрлах Аньси бол *qa-ljub ~ *qā-ləp = qalawu буюу одоогийн Хэрлэн голд баруун талаас цутгах Галуут гол эсвэл өндөр дов дунд байрлах их, бага гүн галуут нуурыг хэлж байна гэсэн шинэ санал дэвшүүлж байна.

¹⁸ Аньхоу голыг эрдэмтэд одоогийн Орхон гол гэж үзжээ (Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 201). Харин бид одоогийн Харуух-Харбух гол бол эртний Аньхоу (*ʔānywā, *ʔānguh) гол мөн гэсэн шинэ санал дэвшүүлж байна.

*qarγwāq) голын баруун эрэгт шилжүүлэн байршуулжээ.¹⁹

Удалгүй долоон сард (8.17-9.15) *сяньбичууд* Хүннүгийн зүүнгарыг довтолжээ. Хариу цэрэглэж тулалдсан Юлю шаньюй алагдав, арьсыг нь *сяньби* нар хуулж авсан ба арваад мянган *хүннү* хүн алагдаж олзлогджээ.²⁰

Хэн тэднийг захирч Хүннүд халдсан нь тодорхойгүй ажээ. Гэхдээ *сяньби* нарын довтолгоон хүннүгийн хүч чадлыг сулруулсан гол хүчин зүйл болсон ба өмнөд хүннүгийн Туньтүхэ (*tödägä) шаньюйн 88 онд хэлсэн, мөн дээр эшилж та бүхэнд толилуулсан мэдээгээр бол энэ байлдааныг санаачилж явуулсан жинхэнэ эзэн нь хожуу ханьгийн Чжан хаан мөн байна.²¹

Хүч нь ихэд суларсан Умард Хүннүгээс зарим овог, аймаг салж нүүх болов. Хожуу Хань улсын бичигт, Чжанхэгийн анхдугаар оны эхээр (87 оны 9-10-р сар) *гюйлань* (*k^hulan), *чубин* (*ɕarə), *худусюй* (*qaracu) зэрэг 58 було (*bölök\oboq)-гийн 8 мянган шилдэг цэрэгтэй, зуун мянгаад²² *хүннүчүүд* Хожуу Хань улсын хилийн Юньчжун, Уюань, Шофан, Бэйди тойргийн гадна очсон гэж бий.²³

Сяньбийн довтолгоон, 58 було салж нүүсэн явдлаар хүннүгийн бужигнаан дууссангүй. Эхлээд Юлю шаньюйг залгамжилсан нэр үл мэдэгдэх хүннү хааны эх өөр баруун сэцэн ван ахыг нь хулгана жилийн хаврын тэргүүн сард (88.2.11-3.10) гудухоу нарын түшмэд бас шаньюй болгов. Ах дүү хаадын тэмцлээс болж ард иргэд ийш тийш нүүж бутран сарних нь нэмэгдэв. Хүннүгийн дотоод хямрал хулгана жилийн намрын тэргүүн сар гэхэд үргэлжилсэн хэвээр байв. Долоон сарын 8 (88.8.13)-нд өмнөд хүннүгийн шаньюйн ордонд зугтан ирсэн *умард хүннү* ноёд орхин гарсан улс гэр нь үймж самуурсаар буй мэдээг улам бататгав.²⁴

Умард Хүннүгийн дотоод самууныг 88 онд шаньюй болсон өмнөд хүннүгийн Туньтүхэ ашиглахаар шийдэв. Энэ үед хожуу ханьгийн хаан Чжан (57-75.9-88.4.9) нас барж, хоёр дахь хатны 10 настай хүү нь хаан болсон ч төрийн эрх Доу хатны гарт төвлөрчээ.

Умард Хүннүд хоёр шаньюй зэрэг гарах зэргээр төр улс нь үймсэн ч тэд нар (ө.х. умард хүннүчүүд) хүн ам цөөний дээр Хожуу Хань улсын нутагт

¹⁹ *Хоу Ханьшу*, 89, 2952; Han dynasty, p. 265; *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 81-82; *Саньгожи, Вэйшу*, 30, 858; Chavannes É. Les pays d'occident d'après le Wei lio – T'oung Pao. Ser. 2. Vol. VI, Leide, 1905, p. 560

²⁰ *Хоу Ханьшу*, 3, 157; 89, 2951; *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 81, 152

²¹ *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 81, 152

²² Өмнөд Хүннүгийн бүлэгт 200 мянга гэсэн. Харин төрийн чухал түшмэдийн намтарт 100 мянга гэжээ.

²³ *Хоу Ханьшу*, 45, 1520; 89, 2951; *Эсгий туургатны түүх*, т. 1017-1018

²⁴ *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 82

суурьшуулж, хөл гарыг нь хумих ханьгийн бодлогод дөрлөгдсөн Өмнөд Хүннүгийн шаньюйд халгаатай хэвээр байсан учир шинэхэн шаньюй Туньтүхэ (*tödägä) умард хүннүгийн шаньюйг «онилж, цэрэг довтолгон устгах» төлөвлөгөө²⁵ боловсруулж 88 оны 8-р сарын сүүлээр ханьгийн хаанд айлтгав. Энэ нь төрийн эрхийг улам бүр атгах болсон Хэсийн хонгил нутгаас гаралтай Доугийн гэр бүлд завшаан болов. Тэр үе нь хожуу ханьгийн нас балчир хааны нэрийн өмнөөс төрийн хэргийг мэдэж байсан Доу хатан төрсөн ах Доу Сянь-ий хийсэн хэргийг яллаж шийтгэхийг аргацаан хойшлуулж байсан цаг байлаа. Өмнөд хүннүгийн шаньюйгаас хожуу ханьгийн хааны ордонд хүргүүлсэн саналыг уншсан хатан, арван таван жилийн өмнө 73 онд Умард Хүннүг 4 замаар довтолсон дайны жанжин асан Гэн Бинээс хэрхэх тухайгаа асуужээ. Умард Хүннүд үүссэн нөхцөл байдал довтолж дайрахад яг тохирч, боломж завшааныг ч Гэн Бин алдахыг хүссэнгүй, харин хожуу ханьгийн төрийн эрхийг атгагч их хатан төрсөн ахдаа ял зэмээс мултрах боломж болгож Хожуу Хань улсын цэргийг дайчилж умард хүннүгийн шаньюйг онилж цэрэглэн уулгалах зарлиг буулгажээ.²⁶

89 оны 8-р сарын байлдаан. Сурвалжийн мэдээгээр тэр үед Доу Сянь нэлээд хүнд байдалд орсон, Хожуу Ханьгийн хаанаас айн эмээж байсан цаг, бөгөөд тиймээс ч гэмт үйлдлээ тэрээр Хүннүтэй тулалдаж цайруулахыг хүсэж байсан гэнэ.

Мөн сурвалжид өгүүлснээр бол, өмнөд шаньюй умардыг дайлах аяндаа цэргээр туслахыг гуйсантай холбогдуулан хожуу ханьгийн хатан хаан ах Сянь-ийг тэрэгт, морьт цэргийн жанжин болгож тамга олгож, янз бүрийн албан тушаалын түшмэл 62-ыг дагалдуулж, туслахаар нь нийслэлийн цэргийн ноён (гиньү) Гэн Бин-ийг томилсон байна. Улмаар бэхлэлт хэрэм давж алслан одож байлдах аянд Лиан (黎陽), Юнин (雍營)-д байрладаг умардын таван жүн²⁷, хойд хил дагуух 12

²⁵ Өмнөд хүннү, зугтаж ирсэн умард хүннү нараас татсан 30 мянган цэргээс 10 мянгыг зүүн гули ван Шизи, зүүн хуянь жичжу ван Сюйзи нарт өгч Шофан-аар, мөн 10 мянгыг зүүн сэцэн ван Аньго, баруун их цецюй ван Жяолэсу нарт өгч Гюйянь-аар бэхлэлт хэрэм давж, өвлийн сүүл сар (89.1.1-29) гэхэд Умард Хүннүгийн нутагт болзсон газраа нэгдэж цааш давших, шаньюй өөрөө үлдсэн 10 мянган цэргээр Уюань, Шофаны хилийн бэхлэлт хэрмийг хамгаалахаар Туньтүхэ төлөвлөж, намрын сүүл сард (88.10.4-11.1) өмнөд хүннү нарын байгуулсан шинэ Хориг (Лун, 龍, *гог < *q^hogiq)-г тахил өргөх үеэр цэрэг агтаа төөлөхөөр болжээ. Мөн нийслэлийн цэргийн ноён Гэн Бин, Дуляогийн жанжин Дэн Хун ба Сихэ, Юньчжун, Уюань, Шофан, Шангюнь-ий захирагч нарт тушааж цэрэг гаргаж хүч хавсрах харин Бэйди, Аньдины захирагчдыг цэргээ авч чухал боомтыг сахиулна уу гэж хүсэжээ.

²⁶ *Northern Frontier*, pp. 264-268

²⁷ Нэг жүн (軍) 12,5 мянгаас 10 мянган цэрэгтэй. Үүгээр баримжаалбал байлдааны байнгын бэлэн байдалд байдаг «умардын 5 жүн» нийт тавь, жараад мянган цэрэгтэй гэсэн үг.

тойргийн цэрэг болон *цян*, *ху* [ху нарт – бага юэчжи, жун, ди 狄, ди 氏 зэрэг хятад биш харь угсаатнууд багтана] нараас цэрэгт татаж илгээхээр шийджээ.²⁸

Баримт мэдээнээс үзвэл Хожуу Хань улс энэ удаагийн дайнд ултай бэлдэж, 88 оны 9-р сараас 89 оны 7-р сарын хорьд дуустал бэлтгэлээ базаажээ.

Улмаар, Хэди хааны юнюань-ий анхдугаар оны намрын долоон сард (89.7.26-8.24) тус бүр 4 мянган морьт цэрэг захирсан Доу Сянь, Гэн Бин хоёр өмнөд хүннүгийн зүүн гули ван Шизи (зүүн хуянь жичжу ван Сюйзи нар)-н түмэн морьт цэрэгтэй нэгдэж Шофан тойргийн Гилу бэхлэлтээс; өмнөд шаньюй Туньтухэ (*tödägä) түм илүү морьт цэрэгтэй Маньигу-гаас; хязгаарын *цян* ба *ху* нарын сайн дурын 8 мянган морьт цэрэгтэй дуляо жанжин Дэн Хун, зүүн сэцэн ван Аньгогийн түмэн морьт цэрэгтэй нэгдэж Гуян бэхлэлтээс мордож бэхлэлт хэрэм давсан байна. Цэргийн тоо 46 мянгад хүрчээ.

Гэхдээ эдгээр цэргээс Туньтухэ шаньюйн захирсан түм илүү морьт цэрэг 88 онд боловсруулсан төлөвлөгөө ёсоор Маньигу-д үлджээ. Учир нь Доу Сяниас гавьяагаа тэмдэглэж Хүннүгийн нутагт, хаданд сийлсэн бичгийн хуулбарт яг дайнд мордсон нь –*өмнөд хүннү, ухуань, жун, ди (氏), цян* нарын ван, гүн ноёдын захирсан болон Хожуу Хань улсын зургаан замын 3 түм илүү цэрэг байсан гэж тодорхой зааж байна. Хожуу Хань улсын цуглуулсан цэргийн олонх нь²⁹ нүүдэлчдийн цэрэг байлаа. Мөн тэнд, байлдааны болоод их цэргийн хоол хүнс зэргийг тээвэрлэх 13 мянган хүнд, хөнгөн тэрэг татан авчирсан гэжээ. Доу Сянь, Гэн Бин нар цугларсан их цэргийг 8 ангид хувааж, 6 замаар давшуулжээ. Ингэж хүчээ хуваарилж бүлэглэн хэдэн замаар аялахаа шийдсэний дараа ханьгийн цэрэг мордож умард хилийн бэхлэлт хэрмийг Гаоцюэ, Гилу зэрэг боомтоор гарч Их говийг туулж болзоо ёсоор Хүннүгийн нутгийн Жое (*təkga < *toγoγo) ууланд цагтаа хүрч хуралдаж цуглав. Тэнд, Доу Сянь жанжин өмнөд хүннүгийн Шизи ноёны дор хятад угсааны 3 жанжин өгч, *өмнөд хүннүгийн* түмэн шилдэг морьт цэргийг манлай болгон илгээв.

Хожуу ханьгийн их цэрэг нутагт нь цөмөрсөнд шаньюй тосож хөдлөөд дайсантай Гило (*kîrâk) ууланд тулгарч байлдсан ч хүчээр ааглуу хожуу Ханьгийн цэрэгт түрэгдэж ухарчээ. Араас нь хожуу ханьгийн их цэрэг мөр даган сэхэл авахуулалгүй мөшгөсөөр умард хүннүгийн шаньюйн өргөө гэр, ачаа хөсөг нь түр буудаллаад байсан Сюйгюйбити (*səjgarjəjdē < *sogabot\soγo'to) нууранд

²⁸ *Хоу Ханьшу*, 23, 814; *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 153.

²⁹ Нийт цэргийн 17 орчим хувь нь л ханьгийн цэрэг байна. Үлдсэн наян хэдэн хувь нь нүүдэлчид ажээ.

хүрч, ачаалж нүүж амжаагүй тэднийг довтолж 13 мянган ноёд, түшмэд, харц иргэдийг нь алж, олзлон, сая гаруй толгой малыг нь булаажээ. Хожуу ханьгийн цэрэг энэ удаад түүхэндээ анх удаа бэхлэлт хэрмээс 3 мянган ли (мянгаад км) газар холдож Яньжань (*ʔenʃan < Инэл буюу Дэлгэрхангай³⁰) уул хүрчээ.³¹

Хүннүгийн нутагт нэлээд гүн цөмөрсөн Хожуу Хань-Өмнөд Хүннүгийн цэрэгт умард хүннүгийн вэнь (онгуд) ван Дусюй (*doktua < *toqtoa), жичжу (нутагчин) ван Вэньу (*ʔuənʃa), фуцой (*baga) ван Люти (*réwtiē < *urudai) нарын ноёд ахалсан 81 було\бүлэг-ийн 200-аад мянган хүн удаа дараалан ирж бууж өгч буйгаа илэрхийлжээ. Бууж өгснөөс бус зарим судлаачдын хэтрүүлж үздэгчлэн тэд хотлоороо өмнө зүг нүүсэн явдал ер болоогүй билээ. Говийн өмнөх нүүдэлчдийн төр улс эсвэл тэдний цэрэг голлосон их хүч говийн умард руу уулгалан довтолох үед говьтой залгаа бүс нутгийн оршин суугчид бууж өгөхөө илэрхийлэх явдал түүхэнд олонтоо гарч байсны нэг л жишээ нь энэ юм. Өөр нэг, олны мэдэх жишээг дашрамд дурдвал Тобагийн хааны довтолгооноор *нирунчууд* бас бууж өгч байсан тохиолдол бий.

90 оны 11-12-р сарын байлдаан. Өмнөд Хүннү-Хожуу Хань улсын хамтарсан цэрэгт ялагдсан ч умард хүннүгийн шаньюй хүчтэй хэвээр байлаа. Тиймээс Хожуу Хань улс Хүннүгийн худалдааны судлыг таслахаар оролдож, үүний тул, бар жилийн зуны таван сарын сүүлээр (90.7.10-аар) Гило уулын тулалдаанд оролцсон Янь Пань дэд сяовэйг Умард Хүннүгийн Иулу-г булаан эзлүүлэхээр илгээв.³²

Харин сурвалжид нэр нь тэмдэглэгдээгүй «умард шаньюй» Хожуу Хань улстай харилцаагаа сэргээхийг оролджээ. Тэрээр, намрын есөн сард (10.12-11.10) нь тус улсад элч илгээжээ.³³

Умард Хүннү, Хожуу Хань улсуудын харилцаа сэргэвэл аюултай хэмээн үздэг Туньтухэгийн хувьд ахиад л эл байдал ашиггүй санагдаж эхэлсэн бололтой. Тэр «умард ордонг» довтолох гэж байгаагаа эзэн улсдаа мэдэгдээд өвлийн арван

³⁰ Доу Сянь жанжны захирсан өмнөд хүннүгийн шилдэг морин цэргийн ангийн хүрсэн Яньжань уулыг олонх эрдэмтэн Хангайн нуруу мөн гэж үздэг байсан. Харин миний бие судалгааныхаа нэг хэсгийг нийтэлсэн 2002 оны өгүүлэлд тус уулыг анх удаа одоогийн Дундговь аймгийн Дэлгэрхангайн нуруу гэж оноосноо уншигчдад хүргэсэн юм (Батсүрэн Б. Хүннүгийн түүхэнд холбогдох зарим газар усны байршлын асуудал – *Түүхийн судлал*. Том. XXXIII, Fasc. 19, УБ., 2002, т. 201). Тэр үед тус уулнаас Ханьгийн жанжны бичээсийг олоогүй цаг байсан санагдана. Харин уулын нэрийг галиглаж үлдээсэн утга үсгийн язгуур дуудлагыг «Инэл» бус арай өөр хэлбэрээр сэргээн туршиж байлаа. Дэлгэрхангай уулын нөгөө нэр Инэл-ийг хожуу үеийн монголын газрын зурагт тэмдэглэсэн байна гэж судлаач Б.Нацагдорж мэдээлсэн билээ.

³¹ *Хоу Ханьшу*, 23, 814-815; *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 153

³² *Хоу Ханьшу*, 4, 170; de Crespiigny, R. *A Biographical Dictionary of Later Han to the Three Kingdoms (23-220 AD)*. Leiden-Boston, 2007, p. 937

³³ *Хоу Ханьшу*, 4, 171

сард (11.11-12.9) зүүн гули ван Шизи-д 8 мянган цэрэг өгч Гилу бэхлэлтээр хэрэм давуулж илгээв. Хожуу Хань улс Гэн Тань-ийг харгалзагч түшмэлээр илгээжээ. Тэгэхдээ хэдий тооны цэрэг өгч явуулсан нь мэдэгдэхгүй байна. Үүнээс үзвэл Хожуу Хань улс харийг харийн гараар устгах сонгодог тактикаа баримталсан хэвээр байжээ.

Хожуу Хань улсын жанжнаар харгалзуулсан³⁴ өмнөд хүннүгийн цэрэг Их говь туулж Жое ууланд ирээд ачаа хөсгөө орхиж, хоёр анги салж хөдөлжээ. Зүүн замын цэрэг умар зүг чиглэн Сихай (*sərhə) нуурыг өнгөрч Хэюнь (*gəjwən) гэдэг газраас хойш орших газарт хүрчээ. Харин баруун замын цэрэг Сюннухэ (*huanagai) гол дагаж Тянь (*tʰen / *xen) уулыг зүүн талаар нь тойрч өнгөрөөд өмнө зүг эргэж Ганьвэй (*kām̩wəj < *qam̩wəj) голыг гатлав. Ингээд тэр хавьд эргэж нэгдсэн өмнөд хүннүгийн цэрэг шөнө умард шаньюйн өргөө гэрийг бүслэв. Мянгаад цэрэгтэй байсан шаньюй тулалдаж байгаад шархдан мориноос унасан ч дахин босож мордоод арван хэдэн хөнгөн хуягтай морьт цэргээ дагуулан бүслэлтийг сэтэлж буруулж амжжээ. *Өмнөд хүннүчүүд* умард хүннүгийн шаньюйн хатныг таван хүүхэд, тамгыг нь олзлов. Мөн 8 мянган албат иргэдийг нь алж олзолсон гэж сурвалжид тэмдэглэсэн байдаг.³⁵

91 оны 3-р сарын байлдаан. Хожуу Хань улс хүч нь эрс суларсан Умард Хүннүгийн шаньюйг нэг мөр устгахаар шийдэв. Сурвалжийн мэдээгээр умард шаньюй өмнөх 2 байлдаанд нийт 21 мянган хүний хохирол үзээд байжээ. Гурван жилийн дараа Хэси-д ирсэн Доу Сянь их жанжин Гэн Куй гэгчийг зүүн саявэй болгож Гюянь-д илгээжээ. Өмнөд хүннүгийн найман мянган³⁶ морьт цэрэг авч бэхлэлт хэрэм давсан Гэн Куй умар зүг давшиж хилийн бэхлэлт хэрмээс 5 мянган ли зайтай орших Цзиньвэй (Жиньвэй, *kām̩wəj < *kögən-ə) уулын орчим нутаглаж байсан шаньюйг гэнэдүүлэн бүслэж амжжээ. Шаньюйн харьяат, ван ноёдоос доош харц ард хүртэлх 5 мянган хүнийг, бүх эд хөрөнгөтэй олзолж харьсан байна. Шаньюй үл мэдэгдэх зүгт зугтан алга болжээ. Гэн Куй буцахдаа

³⁴ Өмнөд хүннүгийн цэргийн үйл ажиллагаа, нөхцөл байдлыг харгалзах үүрэгтэй энэ жанжиндаа Хань улс цөөн ч гэсэн цэрэг өгсөн л байж таараа.

³⁵ *Хоу Ханьшу*, 89, 2953; *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 84

³⁶ Уг эхдээ 800 гэж бий. Маш их эргэлзээтэй тоо. Өмнө нь Хүннүгийн нутагт асар их цэргээр довтолж удаа дараа шаньюйг шахамдуулж, хүчийг нь үлэмж сулруулсан гэсэн нүүдэлчдийн нутагт 800-хан цэргээр цөмөрсөн хятад цэргийн хувьд үндсэн баазаасаа асар хол явж том ялалт байгуулна гэдэг нь бараг бүтэшгүй зүйл. Магадгүй тоогоо алдсан байж болох юм, тиймээс найман мянга гэж орлуулж бичсэн. Түүнчлэн энэ цэрэг нь Хань улсын яг өөрийнх цэрэг биш байх. Ийм холын аянг нүүдэлчин гаралтай цэргүүд л гүйцэтгэж чадах бөлгөө. Эл учирт өмнө нь 90 онд хэрэглэсэн өмнөд хүннүгийн 8 мянган морьт цэргийг Ханьгийн жанжин дахин ашигласан гэж үзлээ.

шаньюйн дүү зүүн гули ван Юйчужянийг шаньюй болгож харьяат 8 було\бүлэг-ийн 20 мянган хүн ардынх хамт нүүлгэн Пулэйхай нуурын дээд биед суулгажээ.³⁷ Үндсэндээ, өмнөд шаньюйн зэрэгцээ бас нэг тоглоомын шаньюй тодруулж нутаг заан суулгасан гэсэн үг. Өмнөд хүннүгийн шаньюй довтолж магад хэмээн уул нутгаас нь холдуулж Бархөл нуурт аваачсан байх.

Хожуу Хань улсаас 89 оны 8-р сард эхлүүлж 91 оны 3-р сард дуусгасан гурван удаагийн холын аян дайн ингэж дууссан юм. Энэ хугацаанд Хожуу Хань улс Умард Хүннүгийн шаньюйн шууд захирч байсан 13 мянга (89.8), 8 мянга (90.11-12), 5 мянга (91.3) буюу нийт 26 мянган ард иргэдийг алж, олзолжээ. Харин 83 оноос хойш Хожуу Хань улсын хараат Өмнөд Хүннүд гурваас-дөрвөн удаагийн нүүдлээр 138780 хүн³⁸ нүүж очжээ. Энэ хугацаанд мөн 11 мянган умард хүннү хүмүүс өмнөд хүннү болон *сяньби* нарын уулга довтолгоонд өртөж алагдсан байна. Өөрөөр хэлбэл 83 оноос хойш Умард Хүннү улс 175800 орчим хүний хохирол үзжээ. Мөн 89 оны байлдааны хөлөөр 200 мянган хүннүчүүд хожуу Ханьгийн захиргааг түр дагасан бол зүүн гули ван Юйчужянь-ий харьяат 20 мянган хүннү хүн Бархөл нууранд түр зуур шилжин сууж байгаад буцжээ.

Чухам, Умард Хүннү улсад 83/89 оноос 91 онд өрнөсөн түүхэн үйл явдал дор хаяж тус улсын харьяат 195-196 мянган хүний амьдралд шууд нөлөөлжээ. Тэгсэн хэдий ч түүхэн баримтаар бол 91 оны үед Умард Хүннү улс нэг бум илүү өрхөөр тоологдох хүн амтай хэвээр байсан бололтой.³⁹ Хүннү нь давхраажсан нийгэмтэй, нарийн бүтэцтэй төр засагтай байсан “зэргийг үндэслэн бодоход ямар ч байсан «бага гэр бүл» байсан ... нэг өрхөд дунджаар 5 хүн байж гэж бодоход хагас сая хүн” болохыг Г.Сүхбаатар тооцоолсон билээ.⁴⁰ Үүгээр баримжаалбал, 89-91 оны дайнд биечлэн өртсөн Хүннүгийн иргэд нь нийт хүн амын 5,2 % болж байна.

Хожуу Хань улсаас өдүүлсэн 89-91 оны дайнаар Умард Хүннү улс мөхөөгүйн бас нэг нотолгоо энэ болох болов уу хэмээн найдаж байна.

³⁷ Хоу Ханьшу, 4, 171; 19, 718-719; *Материалы по истории сюнну*, вып. 2, стр. 84.

³⁸ Умард Хүннүгээс зугтаж очигсоодыг оруулаад 90 он гэхэд Өмнөд Хүннү улс 34 мянган өрх, 237300 хүн ам, 50170 зэвсэг агсаж чадах эртэй болжээ. Энэ тооноос зугтаж очсон 138780 умард хүннү хүнийг хасвал «жинхэнэ өмнөд хүннүчүүд» нь 98520 хүн болж байна. Өмнөд хүннү 49 онд 8 аймаг, түмэн цэрэгтэй (40-50 мянган хүн) байсан. Ер нь өмнөд хүннү нарын дийлэнх нь говийн арын *жинхэнэ хүннү* нараас гарал угсаа огт өөр овог, аймгаас бүрдсэн угсаа-улс төрийн нэгдэл байсан гэж бид үздэг. Гол цөм нь тохар хэлтэн гэж үзэж? буй *линьху* (*krəmǵa), *лоуфань* (*kroban), *байян* (*brāklaŋ) болон *юэчжи* (*uwati) нарт захирагдаж асан *хунье* (*skula?), *сютугэ* (*qutaŋa) нарын овог аймгууд гэж таамаглаж байна. Харин ноёлох ураг, овог нь «эхэн үедээ» *жинхэнэ хүннү* нартай адил байсан нь мэдээж.

³⁹ Таскин, В.С. *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. М., 1984, стр. 71.

⁴⁰ Сүхбаатар, Г. *Сяньби*. Улаанбаатар, 1971, т. 153.

Тэгээд ч энэ их хөл хөлсөөнтэй үеийг эхлэхэд шууд «гар бие оролцсон» 87 оны хоёр шаньюй хоёулаа Хожуу Ханьгийн цэргийн довтолгооноор амиа алдсан гэх мэдээ огт алга. Харин ч «умард шаньюй» гэж нэрлүүлсэн, гурван ч удаа томоохон тулалдаанд орсон, 87 онд *сяньби* нарт алуулсан Юлю шаньюйг албан ёсоор залгамжлагч нэр үл мэдэгдэх шаньюй 91 оны 3-р сард одоогийн Хөгнө хан уул орчмоос зугтаж хаа одсон нь мэдэгдэхгүй байна. Мөн 88 оны 2-3-р сард түүнтэй өрсөлдөж, шаньюй болсон, өмнө нь баруун сэцэн ван цолтой байсан нэгний тухай бүр ямар ч мэдээ алга байна. Үхсэн эсэхийг нь тодруулах баримтгүйн дээр тэрээр Умард Хүннүгийн аль хэсгийг захирч байсныг ч таамаглах боломж алга. Эдгээр нь эхний ээлжинд, лав 91\93 онд Умард Хүннү улс мөхсөн гэж үздэг эрдэмтдийн саналтай эрс зөрчилдөх баримтууд болж байна. Түүнчлэн 92 оноос хойш хожуу ханьгийн төрийн анхаарал Умард Хүннүд биш, харин өөр овог, аймаг, улсууд руу хандах болсон тул Хожуу Ханьгийн бичгийн мэргэдийн анхаарлын гадна Умард Хүннү улс үлдэж хоцрох магадлал бүр ихэссэн гэсэн үг. Чухам хожуу ханьгийн аюулгүй байдалд занал учруулахаа больсон гэж эрх баригчид үзсэн тул *умард хүннүчүүдийг* тэд нэг их тоохоо больсон гэлтэй, эсвэл тэдний «түүх бичлэгийн орон зай» хумигдаж эхэлсэнтэй ч холбоотой байх гэж үзэх нь бодит байдал нийцэх бололтой.

Хожуу Ханьгийн зохион байгуулсан гурван удаагийн аялан байлдсан явдал, тэдний өөрсдийн тусгаар тогтнолд нь аюул учруулж байсан дайсныг устгах зорилготой байгаагүй ажээ. Харин ч эсрэгээрээ харь улсыг хүчирхэгжихээс өмнө нь дарж авах гэсэн зорилго агуулсан эзлэх, түрэмгийлэх, залхаан цээрлүүлэх өнгө аястай, нүүдэлчдийг бие махбодийн хувьд үгүй хийх гэсэн оролдлого болжээ. Түүний дээр энэ удаагийн Хожуу Ханьгийн гадагш үйлдсэн ээлжит түрэмгийлэлд түүхэн бие хүн, гэр бүл, улс төрийн бүлэглэлүүдийн эрх ашиг чухал нөлөө үзүүлжээ. Өөрөөр хэлбэл, түүхэн болоод одоо оршин буй ямар ч улсын эрх мэдэлтэй гэр бүлүүд, эсвэл гэр бүлийн нам бүлэглэл, ураг удмынхаа нөлөөний хүрээг тэлж, эд баялгийг нэмж хуримтлуулах, мөн өмнө өөрсдийн үйлдсэн гэмт үйлдлээ нуух, нэр төрөө аврахын үүднээс улс хоорондын харилцааг хүртэл өөрсдийн бодлого зорилгодоо захируулж, ашиглах явдал түүхэнд олонтоо гарч байсны нэг жишээгээр Умард Хүннүгийн эсрэг 89, 90, 91 онд явуулсан Хожуу ханьгийн залхаан цээрлүүлэх аян дайныг нэрлэж болно гэсэн үг. Чухам, хожуу Ханьгийн төрийг атгаж байсан Доугийн гэр бүл энэ удаагийн дайн байлдааныг зохион байгуулж, явуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Өгүүлэлд гарах, утга үсгээр галиглаж тэмдэглэсэн хүн, газар ус, албан тушаалын нэрсийн дуудлагын сэргээлт:

Хүний нэр

Вэньу	*ʒuənŋa => *onγu?
Гилюсы	*kīruse
Гюйли \Чэли	*kaŋi
Дусюй	*doktua => *toqtoa
Жобин	*təkpeŋ
Имози	*ʒimaksie
Люти	*réwtiē => *urudai
Пуну	*bana
Сюйцой	*q ^h aga
Туньтүхэ	*tʷəndāγǎ => *tödägä
Удадихоу	*ʒahdattiaiguh, *ʒadatdego, *qalatdego
Юлю	*ʒuliu, *ʒəw-rhjəw, *buru

Овог, аймгийн нэр

Байян	*brāklaŋ
Вэньюйду	*ʒuənŋuodok => *onγud (Г.Сүхбаатар)
Гюйлань	*k ^h ulan => *qulan
Линьху	*krəmg ^ʰ a
Лоуфань	*kroban
Сютүгэ	*qutaγa
Худусюй	*qaracu
Хунье	*skula (?)
Чубин	*ɕapə
Юэчжи	*yuwati => *яти (Э.Пуллиблэнк)

Газар усны нэр

Аньси	*ʒānlhəp<*qā-lhəp, *ʒānləp<*qā-ləp, *qaanljub<*qā-ljub => *qalawu
-------	--

Хэрлэнд зөв талаас цутгах Галуут гол, эсвэл Өндөр дов дунд нь байрлах Их, Бага Гүн галуут нуурууд

Аньхоу	*ʔānɣwā, *ʔānguh => *qarɣwāq, Булганы Харуух буюу Харбухын гол
Ганьвэй гол	*kām̄mwəj => *qarɣaɣ, Өмнөговьд байдаг томоохон сайр
Гило уул	*kîrāk => *qira\хяр
Жоэ	*təkga => *toɣoɣo, Өмнөговийн Тогоо уул
Саньмулоузы	*sēm̄mhōkrwācǰé, *sēm̄muklozie
Сихай нуур	*sərhə
Сюйгюйбити нуур	*səjɣarjəjdē => *sogabot ~ *soɣo'ot
Сюннүхэ гол	*huanɣagai => Хонгор
Тянь уул	*tʰen, *xen
Хэюнь газар	*ɣajwən
Цзиньвэй уул	*kēm̄mwəj => *kögən-ə, Булганы Хөгнө уул
Яньжань	*ʔen̄nan => Инэл, Дундговийн Дэлгэрхангай уул

Нэр томьёо

Вэнь ван	*онгуд ван (Г.Сүхбаатар)
Жичжу ван	*nintuk => *нутагчин ван
Фуцуй ван	*baga => бага ван
Шаньюй	*darg ^{wa} => *darɣa ~ *darɣa (Н.Ишжамц)
Було	*bölök (oboq) => МНТ-ны «бүлэг» (иргэн), судалгааны «овог» гэсэн нэр томьёо
Лун (Лунчэн)	*roŋ => *qʰoŋɣ буюу Хориг

Abstract

Later Han, recovered gradually from its damage of economy and strength after political turbulence of several years, sought to invade Northern Xiongnu in 73 AD. It failed, but rulers of Later Han began to change the strategy adopting their traditional policy of “destroying foreigners by hands of themselves”. As a result, attacks of its neighbors against Xiongnu Empire multiplied, often with some interference of Later Han. Youliu chanyu was killed in 87AD by the xianbei (*serbi), one of its main enemies.

Northern Xiongnu began to be ruled immediately by two chanyus. Their struggle for power devastated the empire, and particularly Tuntuhe, a ruler of Southern Xiongnu, tried to defeat completely Northern Xiongnu ruled by his opponent. His effort conformed exactly to a policy of the ruling Dou family of Later Han. By the time Empress Dou

decided to hide her elder brother Dou Xian's crime causing war against the Xiongnu. Later Han under the rule of the empress invaded annually Northern Xiongnu in 89-91 AD when a total of twenty-six thousand men were killed and captured by Han soldiers. Chanyu was exiled during the war according to primary sources.

Examining carefully the war process I attempted to define the historical significance of the war in the article. As for Later Han, the purpose of the war was not to save it from potential menace to safety, but on the contrary to eliminate completely Northern Xiongnu. So, it can be concluded that it was a punitive scourge campaign against Xiongnu, caused mostly by interest of the ruling Dou family.

Ном зүй

1. Хань улсын бичиг. 94
2. Хоу Ханьшу. 3, 4, 19, 23, 45, 89
3. Саньгожи, Вэйшу. 30
4. Таскин В.С. *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. М, 1984
5. Таскин В.С. *Материалы по истории сюнну (по китайским источникам)*. Выпуск 2. М, 1973
6. Chavannes É. *Les pays d'occident d'après le Wei lio –T'oung Pao*. Ser. 2. Vol. VI, Leide, 1905
7. Parker E.H. *Turko-Scythian tribes-After Han dynasty –The China Review*. Vol. XXI, No 4, 1895
8. Сүхбаатар Г. *Сяньби*. Улаанбаатар, 1971
9. Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. Улаанбаатар, 1980
10. Тогтох. *Эсгий туургатны түүх. Хүннүчүүд*. Доорд. Дэжу Чойжи орчуулав. ОМАХХ., 1993
11. Barfield T.J. *The Perilous Frontier: Nomadic Empires and China 221 BC to AD 1757*. Blackwell Publishers, 1992
12. Bielenstein H. *The Restoration of the Han dynasty*. Vol. III. *The People – BMFEA*. No 39. Stockholm, 1967
13. de Crespigny R. *Northern Frontier. The Policies and Strategy of the Later Han Empire*. Canberra, ANU., 1984
14. de Crespigny R. *A Biographical Dictionary of Later Han to the Three Kingdoms (23-220 AD)*. Leiden-Boston, 2007.

89-91 оны үйл явдалтай холбогдуулан дэвшүүлсэн санал,
таамаглалаа тусгасан түүхэн газрын зураг
(Б.Батсүрэн, 2020)

